



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний
бүрэн эрхийг дуусгавар болгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.7 дахь заалт, Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 07, 08 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн дуусгавар болсонд тооцсугай. Үүнд:

1. Б.Цэвэгжав
2. Г.Нандинжаргал
3. Г.Золбоо
4. Д.Даваасүрэн
5. Д.Балжинням
6. М.Отгонбаяр
7. Д.Чинбат
8. С.Энхтайван
9. Б.Очбадрах
10. Б.Осоргарав
11. Д.Отгонбат
12. Ц.Батсайхан

ДАРГА



С.НАРАНЦОГТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.9, 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн, “сайжруулах шаардлагатай” гэж баталсугай.

2. Батлагдсан 2023 оны бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлж эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3. Үндэсний аудитын газрын 2022 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

ДАРГА



С.НАРАНЦОГТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.9, 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн, “сайжруулах шаардлагатай” гэж баталсугай.

2. 2023 онд компанийн үйлдвэрлэлийн зорилтот түвшний биелэлтийг хангаж санхүү эдийн засгийн хувьд ашигтай ажиллаж, өр авлагыг багасгах, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлийн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАРАНЦОГТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.9, 62 дугаар зүйлийн 62.1.1, “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Багануур” ХК-ийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс “гадаад, дотоод худалдаа” гэснийг хассугай.

3. “Багануур” ХК-ийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд “төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа”-г нэмсүгэй.

4. “Багануур” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлийн байгууллагад хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш ажлын 15 өдрийн дотор бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАРАНЦОГТ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023
оны 03 дугаар тогтоолын хавсралт



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

1.1. Компанийн ерөнхий мэдээлэл

1.1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Багануур” ХК (цаашид “компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүрэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхойлох, “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд хэрэгжүүлэх компанийн засаглалын бодлогыг баримтлах, үйл ажиллагааг уялдуулах, хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлж хувьцаа эзэмшигчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.1.2. Компанийн оноосон нэр “Багануур” ХК, англи хэлээр “Baganuur” JSC, товчилсон нэр “БНХК” байна.

1.1.3. Компанийн оршин байгаа газар: Улаанбаатар, Багануур дүүрэг, 2-р хороо, үйлдвэрийн хэсэг.

1.1.4. Компани нь хууль тогтоомжид заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно.

1.2. Компанийн зорилго, үйл ажиллагааны чиглэл

1.2.1. Компани нь байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилго болгон дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1.2.1.1. Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт;

1.2.1.2. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;

1.2.1.3. Цайны газар.

1.2.2. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

1.2.3. Компани нь хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Хоёр. Компанийн хувьцаа, ногдол ашиг

2.1. Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө

2.1.1. Компани нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,974,360 (хорин сая есөн зуун далан дөрвөн сая гурван зуун жаран) ширхэг энгийн хувьцаатай байна.

2.1.2. Хувьцаа нь Хувьцаа эзэмшигчдийн компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн Компанийн аливаа асуудлыг хэлэлцэхэд санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны



дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг Хувьцаа эзэмшигчдийн эрхийг гэрчилнэ.

2.1.3. Хувьцаа нь энгийн хэлбэртэй, нэгж хувьцаа тус бүрд нэг саналын эрхтэй байна.

2.1.4. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг үндэслэн нэмэлт хувьцаа гаргах, давуу эрхийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион, бонд, бусад үнэт цаас гаргах замаар хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж болно.

2.1.5. Нийт гаргасан хувьцааны 15,730,770 (арван таван сая долоон зуун гучин мянга долоон зуун дал) ширхэг нь “Эрдэнэс Монгол” ХХК, 5,243,590 (таван сая хоёр зуун дөчин гурван мянга таван зуун ер) ширхэг нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцаа байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,097,436,000 (хоёр тэрбум ерэн долоон сая дөрвөн зуун гучин зургаа) төгрөг байна.

2.1.6. Компани нийт зарласан энгийн хувьцааны тоонд багтаан хувьцаа шинээр гаргах, хувьцааг эргүүлэн худалдан авах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

2.2. Ногдол ашиг хуваарилах, төлөх

2.2.1. Компанийн ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Гуравдугаар бүлэг. Компанийн засаглалын тогтолцоо

3.1. Компанийн нэгдэл

3.1.1. Компани нь өөрөө болон түүний толгой, охин, зэргэлдээ компани, хуулийн этгээд, төслийн нэгжүүдээс бүрдсэн нэгдэл (цаашид “нэгдэл” гэх)-ийн зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулна.

3.1.2. Компани нь толгой компанитай үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор менежментийн гэрээ байгуулж, хэрэгжүүлж ажиллана.

3.1.3. Энэ дүрмийн 3.1.2-т заасан гэрээний дагуу компани нь толгой компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээг толгой компанийн дүрэмд заасан хязгаарт багтаан Менежментийн гэрээнд тусгана.

3.1.4. Компани нь нэгдлийн зохион байгуулалтыг уялдуулах зорилгоор компанийн зохион байгуулалтын бүтцэд нэгдсэн стратеги төлөвлөлт, санхүүгийн нэгдсэн удирдлага, үйлдвэрлэл технологийн асуудал хариуцсан нэгжтэй байх ба тухайн бүтцийн нэгжийн удирдлагыг толгой компанитай зөвшилцөж, түүний саналаар томилно.

3.1.5. Компани нь толгой компанийн дүрэм, толгой компаниас гаргасан бодлого, нэгдлийн хэмжээнд дагаж мөрдөх журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах бөгөөд дээд шатны байгууллага болон Засгийн газар, УИХ, ҮАБ-ын зөвлөлд танилцуулах шаардлагатай асуудлаа толгой компаниар дамжуулан танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.1.6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд толгой компанийн Гүйцэтгэх удирдлагаар томилолтын удирдамжийг батлуулж, батлагдсан удирдамжийн дагуу ажиллана.



3.1.7. Компанийн Гүйцэтгэх удирдлага гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөр томилолтын удирдамжийг батлуулж, батлагдсан удирдамжийн дагуу ажиллана.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал

3.2.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулиар Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээнд хамааруулсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2.2. Хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61.4, 61.9-т заасан хугацаанд хуралдуулна.

3.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

3.2.4. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд зааснаар дийлэнх олонхоор эсвэл кумулятив аргаар шийдэх асуудлаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.2.5. Хурлын тооллогын комисс, санал авах хуудас, түүнийг хүчингүйд тооцох нөхцөл, эчнээ санал хураалт явуулах журам, хурлын тэмдэглэл хөтлөх зэрэг асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

3.3. Төлөөлөн удирдах зөвлөл

3.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.3.1.1. компанийн засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.1.2. дотоод аудитын нэгжийн дүрэм, үйл ажиллагааны журмыг батлах;

3.3.1.3. компанийн зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох;

3.3.1.4. компанийн гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээний хязгаарыг тогтоох;

3.3.1.5. компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;

3.3.1.6. ТУЗ-ийн дэргэдэх бүтцийн нэгжийн орон тооны дээд хязгаарыг батлах, ажилтнуудын албан тушаалын зэрэглэл, шатлал, цалин урамшууллын хэмжээг тогтоох;

3.3.1.7. ёс зүйн дүрэм батлах,

3.3.1.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хүрээнд тогтоол шийдвэр гаргах.

3.3.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд үүний 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

3.3.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хуульд заасан шалгуур, хязгаарлалтыг хангасан байхаас гадна эрх бүхий этгээдээс болон холбогдох журмаар тогтоосон нэр дэвшигчид тавигдах шаардлага, ур чадвар, мэргэшил, боловсрол, ажлын туршлагын шалгуурыг хангасан байна.



3.3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нээлттэй зарлан сонгон шалгаруулна.

3.3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар сонгоно.

3.3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь хуралдаан байх бөгөөд жилд 4 (дөрөв)-өөс доошгүй удаа хуралдуулна.

3.3.7. Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоох бөгөөд уг журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын эрх үүрэг, хурлын дэг, хуульд зааснаас гадна тавигдах шаардлага, шалгуурыг зохицуулна.

3.3.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг компанийн тухай хуулийн 77.5-д зааснаас гадна толгой компаниас баталсан холбогдох журамд заасан нөхцөлөөр дуусгавар болгож, чөлөөлж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.

3.4. Гүйцэтгэх удирдлага

3.4.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

3.4.2. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ болон толгой компаниас баталсан журмаар олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.4.2.1. Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэл, жил бүрийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төлөвлөгөө, шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.4.2.2. Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон үйл ажиллагааны бусад дүрэм, журмыг батлах;

3.4.2.3. Энэхүү дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах;

3.4.2.4. Эрх, үүргээ итгэмжлэлээр бусдад шилжүүлэх, эрх, үүргээ итгэмжлэлээр бусдад шилжүүлсэн нь гүйцэтгэх захирлыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;

3.4.2.5. Компанийн дүрэм журам, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

3.4.2.6. Хувьцаа эзэмшигчдэд компанийн дотоод дүрэм, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах;

3.4.2.8. Энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

3.4.2.9. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

3.4.2.10. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилж, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас чөлөөлөх;

3.4.2.11. Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд санал оруулах;



3.4.2.12. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

3.4.2.13. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах.

3.4.3. Гүйцэтгэх захирал нь доорх шалгуурыг хангасан байх бөгөөд гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулж сонгоно.

3.4.3.1. 5-аас доошгүй жил Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай, төрийн удирдлага, бизнесийн удирдлага, эрх зүй, санхүү эдийн засаг, эсвэл уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр дээд боловсролтой байх;

3.4.3.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

3.4.3.3. Ял шийтгэлгүй байх;

3.4.3.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

3.4.4. Энэ дүрмийн 3.4.3-т зааснаас гадна Гүйцэтгэх захиралд тавигдах нэмэлт шалгуур болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг хууль, журамд нийцүүлэн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж мөрдүүлнэ.

3.4.5. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь холбогдох хууль тогтоомж, гэрээ болон энэхүү дүрмийн 3.4.4-т тусгагдсан журамд заасан үндэслэлээр дуусгавар болно.

3.5. Эрх бүхий албан тушаалтан

3.5.1. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, дэд захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Дөрөвдүгээр бүлэг. Компани болон түүний удирдлагын хариуцлага

4.1. Компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага

4.1.1. Компанийн энгийн хувьцааг эзэмшигчийн хариуцлага нь компанид оруулсан хөрөнгийн хэмжээгээр хязгаарлагдана.

4.1.2. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээсэн санхүүгийн болон бусад үүргийг хариуцахгүй.

4.2. Компанийн удирдлагын хариуцлага

4.2.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, компаниас хувьцаа эзэмшигчдэд өгөх өгөөжийг байнга нэмэгдүүлэх үүрэг хүлээж ажиллана. Үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захирлын ажил үүргийн гүйцэтгэл, үр дүнг дүгнэж, хариуцлага тооцож ажиллана.

4.2.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нь ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй санхүүгийн хариуцлагыг компанийн их хэмжээний хэлцлийн дүнгээр хязгаарласан хэмжээгээр хариуцлагын даатгалд даатгуулж болно.



4.2.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал нь тухайн албан тушаалд томилогдсон байх хугацаандаа Монгол Улсын Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

Тавдугаар бүлэг. Компанийн санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хяналт

5.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал

5.1.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт (англи хэлээр "International Accounting Standards", товчилсноор "IAS"), санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (англи хэлээр "International Financial Reporting Standards", товчилсноор "IFRS")-ын дагуу хөтөлж, тайлагнана.

5.1.2. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

5.2. Компанийн санхүүгийн хяналт

5.2.1. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт тавих зорилгоор жил бүр хөндлөнгийн аудит хийлгэнэ.

5.2.2. Компани нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дотоод хяналт тавих зорилгоор дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжтэй байх ба энэхүү нэгж нь Төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнана.

5.2.3. Компанийн дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар бүрдүүлнэ.

Зургаадугаар бүлэг. Бусад асуудал

6.1. Компанийн нээлттэй, ил тод байдал

6.1.1. Компани нь ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор компани, нэгдлийн үйл ажиллагааны зорилго, чиглэл, дүрэм, бүтэц, зохион байгуулалт, хувь оролцоо, санхүүгийн тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэрийн талаар болон хууль тогтоомжид заасан шаардлагатай мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.

6.2. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

6.2.1. Компанийн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

6.3. Компанийн хэлбэр өөрчлөх, нэгтгэх, татан буулгах

6.3.1. Компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буулгах үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.

-----ooOoo-----





“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээ тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дүгээр зүйл, 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 06 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээ нь салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй хэмжээтэй байхаар тогтоосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодод орж ажилласан тохиолдолд үндсэн цалингийн дөрөвний нэгтэй тэнцүү хэмжээний нэмэгдэл тооцон олгохоор тогтоосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага нарт тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



С.НАРАНЦОГТ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.7 дахь заалт, 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 07, 08 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хавсралт ёсоор томилсугай.

ДАРГА



С.НАРАНЦОГТ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
№ дугаар тогтоолын хавсралт



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Д/д	Гишүүдийн нэрс	Төлөөлөл	Үндсэн ажил
1	Б.Гэрлээ	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль эрх зүйн газрын ахлах менежер
2	Ч.Дондогмаа	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга
3	И.Лувсанцэрэн	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	ЭХЯ-ны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
4	Д.Эрдэнэбаяр	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	ЭЗХЯ-ны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга
5	М.Мэндбаяр	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	УУХҮЯ-ны Ашигт малтмал газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтсийн дарга
6	Д.Санчир	Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүн	БОАЖЯ-ны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч
7	М.Отгонбаяр	“Монголиан нейшнл коал корпорейшн” ХХК-ийн төлөөлөл	“Монголиан нейшнл коал корпорейшн” ХХК
8	Д.Чинбат	“Монголиан нейшнл коал корпорейшн” ХХК-ийн төлөөлөл	“Монголиан нейшнл коал корпорейшн” ХХК
9	Ц.Болдбаатар	Хараат бус гишүүн	Монголын дотоод аудиторуудын институтын Чанарын менежер
10	Ө.Гэрэлт-Од	Хараат бус гишүүн	МУИС дэд проф, Бизнес консалтинг төвийн захирал
11	Б.Чойжил	Хараат бус гишүүн	Монголын төмөр зам ТӨХК-ийн Боомтын төслийн менежер
12	Б.Мөнхзаяа	Хараат бус гишүүн	Отгонтэнгэр их сургуулийн багш